



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/11

Хэрлэн сум

2018 оныг гэр бүлийн хөгжлийг
дэмжих жил болгон зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6, Гэр бүлийн тухай хуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолын хавсралт, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн жагсаалт батлах тухай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүүхэд, залуучууд, гэр бүлийн чиглэлээр тусгасан зорилтуудыг хэрэгжүүлж Монгол гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, бат бөх хариуцлагатай гэр бүлийг дэмжин, хүүхдийн эрхийг дээдэлж, залуучуудыг хөгжих, суралцах, хөдөлмөрлөх таатай орчин нөхцөлөөр хангах, төрийн үйлчилгээг гэр бүлд хүргэх зорилгын хүрээнд 2018 оныг аймгийн хэмжээнд “Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил” болгон зарласугай.

2. Гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн ажлыг зохион байгуулах аймгийн хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжүүлэхийг аймгийн хороо /Г.Хэрлэнчулуун/-нд, Гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийг орон нутагт тэмдэглэх арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжүүлэхийг сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.


4. Жилийн ажлын үр дүнг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг Засаг даргын орлогч бөгөөд Гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн ажлыг зохион байгуулах аймгийн хорооны дарга Г.Хэрлэнчулуунд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2018 оны
01 дүгээр сарын 25 өдрийн
дугаар захирамжийн хавсралт



ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЖИЛИЙН АЖЛЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Хорооны дарга
Гишүүд

Г.Хэрлэнчулуун
Ж.Гантулга

Аймгийн Засаг даргын орлогч
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн
дарга

Л.Бат-Октябрь
Г.Лхагвахатан
Э.Мөнх-эрдэнэ

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн дарга

С.Нямдаваа
Ч.Баярцолмон

Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга
Хяналт-Шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын хэлтсийн дарга

Н.Хүрэлээ
Ц.Идэрбат

Цэргийн штабын дарга, дэд хурандаа
Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис
хотын захирагч

С.Мөнхцэцэг
Ц.Гэрэлмаа
С.Эрдэнэжаргал

Боловсрол, соёл урлагийн газрын дарга
Эрүүл мэндийн газрын дарга
Хөдөлмөр, халамжийн
үйлчилгээний газрын дарга

Д.Баярхүү

Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын дарга

Ж.Энх-Амгалан
Д.Нэргүйбаатар
Ж.Болд
Б.Дархантөр

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Биеийн тамир, спортын газрын дарга
Цагдаагийн газрын дарга

Ц.Баярмаа
Г.Жаргалбат

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын
дарга
Нийгмийн даатгалын хэлтсийн дарга
Дэлхийн Зөн Монгол Олон Улсын
байгууллагын Бор-Өндөр 2 Орон нутгийн
хөгжлийн хөтөлбөрийн багийн ахлагч

Нарийн бичиг:

Б.Энх-Эрдэнэ

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн
газрын дарга